



Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2025**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2025**

# МЭНДЧИЛГЭЭ

## Эрхэм танд энэ өдрийн мэнд хүргэе.

Манай байгууллагын хувьд 2025 он Монголын хүүхэд бүрийн эрх, хамгаалал, сайн сайхан байдлыг хангах зорилгоо биелүүлэхэд бодит ахиц дэвшил гарсан жил байлаа.

Бид жилийн турш хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, чанартай боловсролыг дэмжих, эрүүл мэнд, амьжиргааг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр төр, иргэний нийгэм, орон нутгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллалаа.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хот болон орон нутгийн сургууль, хамтарсан багуудад амжилттай хэрэгжүүлсэн нь манай гол амжилтуудын нэг байсан юм.

Энэхүү төсөл нь хүүхэд, эцэг эх, багш, хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлснээр хүүхдэд ээлтэй сургуулийн орчин бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан билээ.

Манай хамт олон 2025 онд “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл, “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төсөл зэрэг томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.

Түүнчлэн нийслэлийн Налайх дүүрэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төслөө эрчимжүүлж, усан хангамж, хүлэмж зэргээс бүрдсэн цогцолбор байгуулан, олон мод, бут тарьж, иргэд, хүүхэд залуусын экологийн боловсролыг дээшлүүлж байна.

Эрүүл мэнд, боловсролын салбарт бага насны хүүхдийн цогц, хүртээмжтэй хөгжлийг дэмжих шинэ санаачилга эхэлж, хөгжлийн хоцрогдол, эрсдэлтэй нөхцөлд буй хүүхдүүдэд чиглэсэн эрт илрүүлэг, дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэхэд анхаарлаа хандууллаа.

2025 онд эрүүл мэндийн төслийн хүрээг тэлж, Завхан аймгийн Түдэвтэй суманд шүдний тасаг шинээр байгуулж, тоног төхөөрөмжөөр хангаснаар төвөөс алслагдсан орон нутгуудад зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулсан юм.

Хүүхдийг Ивээх Сангаас Говь-Алтай, Ховд аймагт “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг анх удаа,

өндөр хэмжээнд зохион байгууллаа. Эдгээр чуулга уулзалтад аймгуудын Засаг дарга, сумын удирдлагууд, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль сахиулах салбарын мэргэжилтнүүд, эцэг эх, хүүхдүүд зэрэг 200 гаруй төлөөлөл оролцжээ. Энэхүү арга хэмжээнүүдээр хүүхэд хамгааллын тогтолцоо, салбар дундын үйл ажиллагааг бэхжүүлж, эх, хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг тодорхойлон, энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийн чадавхыг нэмэгдүүлсэн байна.

Хүүхдийг Ивээх Сан сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах төслийн дараагийн үе шатыг нийслэл хот болон Говь-Алтай, Ховд, Баян-Өлгийн аймагт 2026 оноос гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэх болсноо дурдахад таатай байна.

Үүнээс гадна бидний урилгаар Япон, Австрали, БНСУ, Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн захирал, ажилтнууд Монголд зочиллоо. Эдгээр айлчлалууд нь туршлага, үр дүнгээ хуваалцах, түншлэлээ бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ шатанд гаргах нэн таатай боломж олголоо.

Хүүхдийг Ивээх Сан 2025 онд төсөл, хөтөлбөрүүдийн үр шимийг 38,073 хүүхэд, 1,882,175 эцэг, эх, багш, ажилтнууд, олон нийтэд шууд хүргэсэн байна.

Манай бүхий л үйл ажиллагааны гол цөм нь хүүхэд байдаг. Монголын хүүхдүүд бол бидний ажлын үр шимийг хүртэгчид төдийгүй, өөрсдийн дуу хоолойг хүргэж, шийдлийг тодорхойлон, илүү сайхан ирээдүйг хамтдаа бүтээхэд тусалдаг өөрчлөлтийн төлөөлөгчид юм.

2025 онд гаргасан амжилтууд нь манай ажилтнуудын тууштай байдал, мэргэжлийн өндөр үр чадвар, бидэнтэй хамтран ажилладаг төр, засгийн байгууллагууд, хөгжлийн түншүүд, хандивлагчид болон орон нутгийн иргэдтэй тогтоосон бат бөх түншлэлийн ачаар бий болсон билээ.

Та бүхний тууштай дэмжлэг, хамтын ажиллагаанд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Л.Баян-Алтай  
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь  
Суурин төлөөлөгч



# ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА



Хүүхдийг Ивээх Сан 1919 онд байгуулагдсан бөгөөд хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг бөгөөд шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага юм.

Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, онцгой байдлын үеэс урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн.

Бид хүүхдийг хамгаалж, эсэн мэнд амьдрах, хөгжих эрхийг хангахын төлөө тэмцэж, хүүхдийг өөрт байгаа боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахад нь тусалдаг. Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийг сонсож, тэднийг оролцуулж, хүүхдийн амьдралд чухал

нөлөө үзүүлэх аливаа шийдвэр гаргахдаа тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгдөг хариуцлагатай нийгмийг цогцлоохын төлөө ажилладаг.

Хүүхдийг Ивээх Сан өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд өргөжин тэлж, өнөөдөр дэлхийн 101 улсад үйл ажиллагаа явуулж байна. 1994 онд нээгдсэн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр 1994-2009 онд Их Британийн Хүүхдийг Ивээх Сангийн, 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох арга зүйг эрхэмлэн ажиллаж байна.



## АЛСЫН ХАРАА

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бодит дэвшил гаргах замаар хүүхдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах



## МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- Боловсрол
- Хүүхэд хамгаалал
- Хүүхдийн эрхийн засаглал
- Хүүхдийн ядуурлыг бууруулах
- Эрүүл мэнд
- Хүмүүнлэгийн яаралтай тусламж
- Уур амьсгалын өөрчлөлт

## ДАРААХ ГУРВАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД БОДИТ ДЭВШИЛ ГАРГАХАД ЧИГЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА:



### ЭСЭН МЭНД АМЬДРАХ

Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг таслан зогсооно



### СУРАХ


Бүх хүүхэд чанартай суурь боловсрол эзэмшиж чаддаг болсон байна



### ХАМГААЛУУЛАХ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчдэг болсон байна

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ОРОН НУТАГ



# 2025 онд



**38,073**

Төслүүдийн үр шимийг 38,073 хүүхэд, 1,882,175 насанд хүрэгчид шууд бусаар хүртсэн байна.



**5,529**

Суралцагч ESEL (Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэх)-ийн суурь үр чадвар эзэмшжээ.



**10,453**

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн үр шимийг 10,453 хүн шууд хүртсэн байна.



**1,940**

Говь-Алтай аймгийн Чандмань, Завхан аймгийн Түдэвтэй сумын шүдний кабинет 1,940 хүнд шүдний тусламж үйлчилгээ үзүүллээ.



ЭЦЭГ ЭХИЙН ЭЭРЭГ ХАРИЛЦАА, ЗӨВ ҮЛГЭР ДУУРАЙЛЛААС ГЭР БҮЛИЙН ОРЧНЫ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ ЭХЭЛНЭ.

**1,499,849**

Хүүхэд хамгааллын төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоо, ойлголтыг сайжруулах зорилготой “Мэдэж, оролцож, хамтдаа хяная” нөлөөллийн аянд эцэг эх, асран хамгаалагчид, хүүхдүүд зэрэг нийт 1,499,849 хүн хамрууллаа.

# 2025 онд



**135,000**

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд хосолсон сургалт явуулах орчин бүрдүүлж, “Цахим танхим” дөрвөн холимог сургалтын модулийг нэвтрүүлснээр 85 сургуулийн 135,000 сурагч хамрагдав.

**206**

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд 206 тогооч, хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний онол, дадлага хосолсон сургалтад хамрагдаж, мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэв.

**14,203**

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр шим сургуулийн багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч зэрэг 14,203 хүн, 25,399 сурагч, хүүхдэд шууд хүрчээ.

**4,000**

“Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн талбайд 23 төрөл зүйлийн 4,000 мод тарив.

**17,730,000**

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрт хамрагдаж, үе тэнгийн дэмжигчээр бэлтгэгдсэн сурагчдын 15 бичил төсөлд 17,730,000 төгрөгийн санхүүжилт олгов.



## “СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах” төслийг Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр 2023-2025 онд амжилттай хэрэгжүүлэв. Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг, Говь-Алтай, Ховд аймгийн 14 сургууль, 14 Хамтарсан багуудыг хамруулж, сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг бэхжүүлэхэд чиглэсэн юм.

Түүнчлэн төслөөр, сурагчдын сурч хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар чиглүүлэх, дэмжихэд сургуулийн багш, ажилтнууд болон эцэг эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах, сургууль ба хамтарсан багийг хүүхэд хамгаалалд хамтран ажиллахад арга зүйгээр дэмжих, хүүхдийн оролцоог хөгжүүлэх замаар тэдэнд тулгарч буй бэрхшээлийг даван туулах, үе тэнгийнхэндээ зөвлөн туслах үр чадварыг эзэмшүүлэхэд анхаарал хандуулжээ.

## СҮҮЛИЙН ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТҮГЭЭЛТ

- 2025 он нь төслийн хэрэгжилтийн 3 дахь жил бөгөөд төслийн үр дүнг үнэлэх, бий болсон туршлага, сургамж дээр үндэслэн санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор төслийн эцсийн үнэлгээг хийж, гарсан үр дүнг гарааны судалгааны үр дүнтэй харьцуулсан тайланг боловсруулан гаргалаа. Мөн үнэлгээний үр дүнг хамтрагч байгууллагууд, олон нийтэд таниулах ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Төслийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэх тайлагнах зорилгоор төслийн хаалтын үйл ажиллагааг аймаг, нийслэл, яамд, агентлагуудыг оролцуулан 3 түвшинд зохион байгуулж, холбогдох зөвлөмжийг яамд, агентлагуудад гардуулан өглөө.

### Бодлогын нөлөөлөл, үндэсний хэмжээний түгээн дэлгэрүүлэлт

- Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах ажил үр дүнгээ өгч байгаа бөгөөд “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар” гарын авлагыг Боловсролын яамнаас талархалтай хүлээн авч, тус гарын авлагын сайжруулалтыг зөвлөхөөр уншуулах, засварлах ажлыг хариуцан, Монгол Улсын бүх сургуулиудад түгээн дэлгэрүүлэхээр шийдвэрлэв. Төслийн хүрээнд 2 дахь шатны хэвлэлийн зардлыг хариуцан ажиллалаа.

### Чадавх бэхжүүлж, хэрэгжүүлсэн гол үр дүн (3-р жил)

Төслийн 3 дахь жилд сургуулийн хүүхэд хамгааллын механизмыг бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн ажлуудыг бататгах, сургууль ба Хамтарсан багийн хамтын ажиллагааг ахисан түвшинд гаргах, сургуулийн эцэг эхийн зөвлөл, хүүхдийн бүлгийг сургуультай хамтран хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа

хэрэгжүүлэхэд дэмжих зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

#### • Шинэлэг арга зүй, ойлголт

Сургууль, хамтарсан багуудын хүүхэд хамгааллын кейс дээр ажиллах чадавхыг бэхжүүлэх зорилгоор кейс менежментийн ахисан шатны сургалтыг 97 хүнд зохион байгууллаа. Сургалтыг Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын эвслээс боловсруулсан “Хамгааллын алхамууд: Кейс менежментийн нийтлэг арга зүйн шинэчилсэн багц”-ын агуулгаар зааж, оролцогчдод шинэлэг арга зүй, ойлголтыг таниуллаа.

#### • Туршлагаа хуваалцаж, харилцан суралцав

Сургууль, хамтарсан багуудын төлөөлөн 95 хүнийг хамруулан туршлага судлах үйл ажиллагааг Улаанбаатар хотод зохион байгуулж, зорилтот сургуулиуд, хамтарсан багууд туршлагаа таниулан, харилцан мэдээлэл солилцсон нь үр дүнтэй бөгөөд идэвх, санаачилга нэмэгдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.

#### • Хүүхдийн оролцоо ба эрхийн талаарх мэдлэг

“Хүүхдийн утга төгөлдөр оролцоо”, “Хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэнд, хэзээ, хэрхэн хандах вэ” сургалтыг сургуулийн



140  
багш



1,400 дэмжигч  
хүүхдүүдэд

заан сургаж, эдгээр  
багш, сурагчдаар  
дамжуулан



нийт 21,457 сурагч,  
хүүхдүүдэд хүргэлээ.

#### • Эцэг эхийн зөвлөл ба оролцоо

Сургуулийн эцэг эхийн зөвлөлийг хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах зорилгоор сургуулиудад хүүхэд хамгааллын төслийг боловсруулан, хэрэгжүүлэхэд дэмжин ажиллалаа. Ингэснээр төслийн зорилтот 14 сургуулийн эцэг эхийн зөвлөлүүдээс 2 үе шаттайгаар бичил төслүүдийг хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэн нийт



11,000 эцэг эх, асран хамгаалагчид



12,302 сурагчдыг хамрууллаа.

#### • Хүүхдүүдийн хэрэгжүүлсэн бичил төслүүд

“Би найзаа дэмжинэ” хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн бүлгүүдийн санаачилгаар хүүхэд хамгааллын чиглэлээр бичил төслүүдийг 2 үе шаттайгаар сургуультай хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр хүүхдүүд өөрсдөө төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах аргачлалд суралцлаа. Хүүхдийн бүлгүүдийн санаачилж хэрэгжүүлсэн төслүүдэд нийт 12,935 сурагч хамрагджээ.

#### Тогтолцоо бэхжүүлэх, үйлчилгээ сайжруулах хэлэлцүүлэг

- Хүүхдийг Ивээх Сангаас “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг Говь-Алтай, Ховд аймгуудын Засаг даргын Тамгын газруудтай хамтран, нийт 211 мэргэжилтэн хамруулан зохион

байгуулж, хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах стратегиа тодорхойлох, мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэхэд хамтран ажилласан байна.

#### Санхүүжүүлэгчийн оролцоо

- Төслийн санхүүжүүлэгч байгууллага болох Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангаас 4 хүний бүрэлдэхүүнтэй баг айлчлан ирж, Улаанбаатар хот, Ховд, Говь-Алтай аймгийн 5 сургууль, 5 хамтарсан баг, сургуулийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцлаа.

#### Олон нийтийн мэдлэг, нөлөөлөл

- Хүүхэд хамгааллын төсвийн талаарх олон нийтийн ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилготой “Мэдэж, оролцож, хамтдаа хяная” сошиал болон хэвлэл мэдээллийн аяныг 2025 онд зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд 5 видео бичлэг, 5 постер, 5 рийл, 3 нөлөөлөгчийн контент, 1 ТВ ярилцлага, 1 радиогийн ярилцлага, 2 сонины нийтлэл, 2 вэбсайтын ярилцлагыг бэлтгэж зохих хэвлэл, мэдээлэл, сошиал орчинд нийтлүүлж олон нийтэд түгээсэн байна. Энэхүү нөлөөллийн аяны мэдээлэл 1,499,849 хүнд хүрч, хандалт авчээ.
- Төслийн дараагийн шатыг боловсруулан санхүүжүүлэгч байгууллагаас зарласан төслийн уралдаанд шалгарснаар, төсөл үргэлжлэн 3 жил хэрэгжих боломж бүрдсэн байна.



## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Төслийн хүрээнд зорилтот 14 сургууль,  
14 Хамтарсан багийн үр шим хүртэгчдийн тоо:

**16,090**

Сургуулийн багш,  
ажилтнууд, эцэг эхчүүд  
(шууд үр шим хүртэгчид)

**25,399**

Сургуулийн хүүхдүүд  
(шууд үр шим хүртэгчид)

**1,177**

Насанд хүрэгчид  
(шууд бус үр шим хүртэгчид)

**21,632**

Сургуулийн хүүхдүүд  
(шууд бус үр шим хүртэгчид)



Миний нэрийг Ч.Сүндэръяа гэдэг. Би Ховд аймгийн Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангид суралцдаг.

Манай сургуулийн нийгмийн ажилтан Нямдаваа багш “Хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэзээ, хэнд, хэрхэн хандах” талаар сургалт хийсэн юм.

Би өмнө нь хүүхдийн эрх зөрчигдөхөд яг хэнд хандах, яаж хэлэхээ мэддэггүй байлаа. Заримдаа айна, заримдаа зүгээр л өнгөрөөнө. Гэхдээ энэ сургалтад суугаад би маш их өөрчлөгдсөн. Одоо өөрийнхөө болон найз нөхдийнхөө эрх зөрчигдөхөд хэн дээр очиж, юу гэж хэлэхээ мэддэг боллоо.

Хүүхэд бүр эрхтэй гэдгийг ойлгосон. Багш нар, нийгмийн ажилтнууд ч биднийг сонсож, хамгаалж чаддаг гэдгийг мэдрэх үнэхээр сайхан байв.



Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 17-р сургуулийн “Миний дэвтэр” төслийн багийн багш, сэтгэл зүйч болон сурагчид



Хүүхдийг Ивээх Сан “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг Ховд аймгийн Жаргалант суманд 2025 оны 11 дүгээр сарын 5-6-нд зохион байгууллаа. Энэхүү чуулга уулзалт Ховд аймагт хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдэл гарцыг хамтдаа боловсруулах, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулах, боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын механизмыг сайжруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилготой байв. Чуулга уулзалтад аймаг болон 17 сумын удирдлага, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, цагдаагийн байгууллага, эцэг эх, хүүхдүүдийн төлөөлөл зэрэг 100 гаруй хүн оролцсон юм.



Говь-Алтай аймгийн Алтай хотод “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 7-8-нд зохион байгуулав. Энэхүү чуулга уулзалт нь Говь-Алтай аймагт Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах салбар дундын хэлэлцүүлэг өрнүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлох, хүүхдэд хамгааллын болон боловсролын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилготой байв. Чуулганд аймгийн болон 18 сум, 2 тосгоны удирдлагууд, сургуулийн нийгмийн ажилтнууд, багш нар, эрүүл мэнд, нийгмийн халамж ба цагдаагийн байгууллагын төлөөлөл, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын мэргэжилтнүүд, Боловсролын газрын төлөөлөл, эцэг эх болон хүүхдүүдийн төлөөлөл зэрэг 100 гаруй хүн оролцсон юм.

## “ӨДӨР ТУТАМ ХЭРЭГЛЭХ ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГА” ДЭД ХӨТӨЛБӨР

Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн урт хугацааны стратегийн хүрээнд хэрэгжүүлж буй “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөр нь хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг бүх орчинд халах зорилготой юм. Хөтөлбөр нь эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг, үр чадвар олгож, хүчирхийллийг таслан зогсоох үр дүнтэй арга зүйг түгээн дэлгэрүүлдэг. Ингэснээр хүүхдэд аюулгүй, халамжтай гэр бүлийн орчин бүрдүүлэх, эерэг харилцааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

### Сургалтын тогтолцоог бэхжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэв

2025 онд “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн сургалтын тогтолцоог бэхжүүлэх, хөтөлбөрийг орон даяар түгээн дэлгэрүүлэхэд гол анхаарлаа хандууллаа. Энэ хүрээнд хөтөлбөрийн зорилго, ач холбогдлыг олон нийт болон холбогдох байгууллагуудад таниулах ажлыг эрчимжүүлж, Говь-Алтай, Ховд, Завхан, Баянхонгор аймгуудын Засаг даргын Тамгын газарт хөтөлбөрийг танилцуулсан. Мөн Монголын хөрөнгийн бирж, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв, Мон-Энко ХХК зэрэг байгууллагуудад танилцуулах уулзалт хийж, бусад байгууллагад албан бичиг илгээсэн нь хамтын ажиллагааны суурийг бататгав.

“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн үндэсний сургагч багшийн шаардлагыг биелүүлж, 2022–2025 онд суралцаж төгссөн таван хүн

Канадын PDEL байгууллагаас албан ёсны гэрчилгээг гардан авлаа. Энэхүү амжилт нь үндэсний хэмжээнд хөтөлбөрийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдээ эерэг аргаар өсгөн хүмүүжүүлэх мэдлэг, хандлага, зан үйлд нөлөөлөх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах үндэсний чадавхийг бэхжүүлэхэд чухал алхам боллоо.

### Аймгийн түвшний хэрэгжилт ба шууд нөлөө

Хүүхдийг Ивээх Сан, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран тус аймгийн 18 сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд, Насан туршийн суралцахуйн төвийн багш нар, аймгийн Боловсролын газар, Насан туршийн суралцахуйн төвийн мэргэжилтнүүдээс бүрдсэн 52 хүнийг 2025 оны 10 дугаар сард “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн чиглүүлэгчээр сургаж бэлтгэлээ. Сургалтын үр дүнд оролцогчид эерэг хүмүүжлийн арга зүйг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэх үр чадвар эзэмшиж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр сумандаа манлайлан ажиллах чадавхтай болов. Цаашид эдгээр чиглүүлэгчид аймгийн хэмжээнд хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх, эцэг эх, багш нарт мэдлэг түгээх гол хүч болж ажиллах юм.

2025 оны 10-12 дугаар сард Говь-Алтай аймгийн 15 сум болон аймгийн төвийн хоёр байгууллага нийт 17 байршилд “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлээ.



“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн чиглүүлэгч бэлтгэх сургалт. Говь-Алтай аймгийн Алтай хот. 2025 оны 10 дугаар сарын 9-12

Хөтөлбөрийн хүрээнд 340 эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг, үр чадвар эзэмшиж, гэр бүлийн орчинд хүчирхийлэлгүй, эерэг харилцааг төлөвшүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан нь төслийн шууд үр дүн байв.



## “ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ, ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийг 2024 оны 3 дугаар сарын 30-наас эхлэн Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Баянхонгор, Сэлэнгэ аймагт хэрэгжүүлж байна.

Энэхүү төсөл нь өрхийн эрүүл мэндийн төвүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссууд, цэцэрлэгүүд зэрэг орон нутгийн нийгмийн үйлчилгээний төрийн байгууллагуудын чадавхийг сайжруулах замаар бага насны хүүхдийн хөгжлийг цогц, хүртээмжтэй дэмжих загвар бий болгон бэхжүүлэх зорилготой юм.

Үүний зэрэгцээ төв болон орон нутгийн төрийн байгууллагууд энэ чиглэлээр гарсан бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бодлогын харилцан яриа өрнүүлэх, хэрэгжилтийг дэмжих механизмаар дамжуулан бага насны хүүхдийн цогц, хүртээмжтэй хөгжлийг дэмжих хүчин чармайлтаа эрчимжүүлжээ.

## ТӨСЛИЙН ТООН ҮР ДҮН:

- 2025 оны 5 дугаар сард Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийг 2025-2027 онд хамтран хэрэгжүүлэхээр Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулав. Төслийн үр дүн, хэрэгжилтийг танилцуулах семинар зохион байгууллаа.
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг бага насанд нь эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэгтэй холбоотой бодлогын орчинг үнэлэх, төслийн 2 дахь жилд хамрагдсан өрхийн эрүүл мэндийн төвүүд, салбар комисс, цэцэрлэгүүдэд үйлчилгээ авч буй үр шим хүртэгчдийн төслийн өмнөх нөхцөл байдлыг тодруулах зорилготой суурь судалгааг 2025 оны 5-8 дугаар сард хийв. Нийтдээ 297 хүн суурь судалгаанд оролцсон бөгөөд асуулга, мэдээлэл авах зорилгоор ярилцлага хийх зэрэг тоон болон чанарын аргуудыг хослуулан ашиглажээ.
- Цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан дэд бүтцийг сайжруулах ажлын хүрээнд Баянхонгор, Сэлэнгэ, Улаанбаатар хотод шинээр төсөлд хамрагдсан таван цэцэрлэг, таван өрхийн эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан налуу зам барих, бариул суурилуулах, ариун цэврийн өрөөг шинэчлэх засварын ажлууд хийж гүйцэтгэсэн.

Зорилтот газрууд	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	Цэцэрлэгүүд
Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг	“Нэмүүлэн” Өрхийн эрүүл мэндийн төв	320 дугаар цэцэрлэг
Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг	“Анан” Өрхийн эрүүл мэндийн төв	81 дүгээр цэцэрлэг
Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	“Мэнд аривжих” Өрхийн эрүүл мэндийн төв	83 дугаар цэцэрлэг
Баянхонгор аймаг	“Оточ Мандал” Өрхийн эрүүл мэндийн төв	1 дүгээр цэцэрлэг
Сэлэнгэ аймаг	“Номт Хан” Өрхийн эрүүл мэндийн төв	3 дугаар цэцэрлэг

- Цэцэрлэгийн багш нарын дунд ганцаарчилсан сургалтын практик аргуудын талаарх мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийг дэмжих эцэг эхчүүдийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, нярай болон бага насны хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх талаар өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын арга зүйг сайжруулах, салбар комиссын гишүүдийг чадавхжуулах зорилгоор дараах сургалтын гарын авлага, модулиудыг дахин боловсруулж, хэвлүүлэв.

### 01.

“Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх” Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарт зориулсан сургалтын гарын авлага

### 02.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага

### 03.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль

### 04.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх арга зүй

### 05.

Эцэг эх-багштай харилцах дэвтэр

### 06.

“Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ын тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах заавар, аргачлал

- Дээрх сургалтын модулиудад үндэслэн цэцэрлэгийн багш, ажилчид, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнууд болон орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнуудад зориулсан дараах сургалтыг 2025 оны 8-р сараас 10-р сарын хооронд зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан оролцогчид ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийг дэмжих шинэ аргуудыг сурч, хүртээмжтэй дадал зуршлаа сайжруулсан.

### 1. Сургалтын жагсаалт

	Сургалтын нэр	Сургалтад хамрагдсан оролцогчдын тоо (1 ба 2-р жилийн зорилтот бүлгүүд)
Б1	“Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх арга зүй” өрхийн эмч нарт зориулсан сургалтын гарын авлага	54 эмч, эмнэлгийн ажилтнууд
Б1	ӨЭМТ-ийн эмч нарт зориулсан сэргээн засах/хэл яриа/хөдөлгөөн заслын сургалт	59 эмч
Б2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, Боловсрол, Нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага	29 комиссын гишүүн
Б2	Зорилтот 2 аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран явуулсан эцэг эхчүүдэд зориулсан сургалт	131 эцэг эх
Б2	Монгол-Танака Бине сорил авагч бэлтгэх сургалт	17
Б3	Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль	318 багш
Б3	“Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модуль	68 багш
Б4	“Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модуль	323 багш, 588 эцэг эх, асран хамгаалагч
Б4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтарсан цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт	300 эцэг эх

- Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад талуудын оролцоотойгоор тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг тэгш, хүртээмжтэй, цогц үйлчилгээнд хамруулах бодлогын уулзалтуудыг тогтмол зохион байгуулав. Уулзалтын үр дүнд эрх зүйн баримт бичгийн төслийг шинэчлэх, дахин боловсруулахад

дэмжлэг үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, Боловсролын сайдын 2025 оны А/404 тоот тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалт”-ын хөтөлбөрийг баталсан. Энэхүү сургалтын хөтөлбөр нь хүүхэд бүрийн хувийн хэрэгцээнд суурилсан сургалтын аргыг дэмждэг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн

хамгааллын комиссын дүрмийг Засгийн газрын хуралдаанаар шинэчлэн батлуулсан.

- Хүүхдийн оюун ухааны хөгжлийг тодорхойлох Монгол-Танака Бине сорил авагч бэлтгэх сургалтыг нь МУБИС-тай хамтран зохион байгуулав. Үүгээр зорилтот цэцэрлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, нөхөн сэргээх төвүүд болон орон нутгийн хэлтсийн 17 оролцогчийг сорил авагчаар сургажээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, өрхийн эрүүл мэндийн төвүүд, цэцэрлэгүүд болон мэргэжлийн багуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор нийт 54 оролцогч хамруулсан 10 уулзалт, 4 хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
- Төслийн хүрээнд тусгай хэрэгцээтэй 28 хүүхдэд дэмжлэг үзүүлж, салбар комиссын хуралдаанаар

хувь хүний хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулсан.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлгийн ач холбогдол, бага насны хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Эрт анхаарья” социал медиа болон уламжлалт хэвлэл мэдээллийн кампанит ажлыг 2025 оны 10 дугаар сараас 2026 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Кампанит ажлын хүрээнд 4 сурталчилгааны видео, 3 зурагт хуудас, 5 амжилтын түүх, хэвлэл мэдээлэл, веб хуудас, радио, телевизэд зориулсан 20 нийтлэл, ярилцлага зэрэг олон төрлийн мэдээлэл материал боловсруулж, олон нийтэд түгээв.
- Эдгээр мэдээллүүдийг социал медиа болон уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр түгээсэн байна. Энэхүү нөлөөллийн аян 2.7 сая хандалт авчээ.

## ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧИД:

 <b>22</b> ӨЭМТ-ийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн ажилтнууд	 <b>8</b> цэцэрлэгийн эмч	 <b>7</b> Аймаг/дүүргийн ЭМТ-ийн эмч нар	 <b>3</b> Аймаг/дүүргийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтнүүд
<b>33</b> ХБХЭБНХ-ны салбар комиссын гишүүд	 <b>16</b> 3 яамны мэргэжилтнүүд	 <b>324</b> Цэцэрлэгийн багш, ажилтнууд	 <b>18</b> Аймаг/дүүргийн ЗДТГ-тай холбогдох мэргэжилтнүүд
<b>9,435</b>  ӨЭМТ-ийн үйлчилгээнд хамрагдаж буй бага насны хүүхдүүд (үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 80 хүүхэд)	 <b>31</b> Бусад  <b>1,811</b> Шууд үр шим хүртэгч насанд хүрэгчид	 <b>1,349</b> Эцэг эх, олон нийт	<b>9,463</b>  Шууд үр шим хүртэгч хүүхэд




**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга В.Наранчимэг:**

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад тогтмол хамрагдсанаар манай аймгийн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүний нөөц чадавхжсан гэж хэлмээр байна. Энэхүү төслийн хугацаанд манай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн мэдлэг, үр чадвар ч мэдэгдэхүйц сайжирчээ. Мэргэжсэн мэргэжлийн багтай хамтран бэлтгэсэн мэдээллийн чанар сайжирч, Өрхийн эрүүл мэндийн төвд шинэ лавлагааны маягыг нэвтрүүлсэн.

**Зорилтот дүүргийн цэцэрлэгт тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл, засварын ажлыг хүлээлгэн өгөх ёслол. 2025 оны 10 дугаар сарын 27. Улаанбаатар хот**

## “ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ



Боловсролын яам “Боловсролын дэлхийн түншлэл” байгууллагын буцалтгүй тусламжаар “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийг 2022-2025 онд амжилттай хэрэгжүүлэв.

Төслийн Санхүүгийн зохицуулагчаар Австралийн Хүүхдийг Ивээх Сан, Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан ажиллаж төслийн хэрэгжилтийг зохион байгуулахад Боловсролын яаманд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлсэн юм. Энэхүү төсөл нь боловсролын салбарын тэргүүлэх гурван чиглэлүүд болох “Тэгш хамруулан сургах боловсрол”, “Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ” болон “Хосолсон сургалт” гэсэн гурван бүрэлдэхүүний хүрээнд хэрэгжсэн байна. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төсөл 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн нийт 273 ерөнхий боловсролын сургуульд хүрч, Монголын боловсролын хүртээмж, тэгш байдал, чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулжээ.

Төлөвлөсөн үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлэх, санхүүжилтийг оновчтой ашиглахын тулд төслийн санхүүгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг санхүүжүүлэгч байгууллагад болон Сангийн яаманд хүргүүлсэн юм. Үүний үр дүнд 6 сар сунгах хүсэлтийг баталж, төслийн хугацааг сунган, үлдсэн үйл ажиллагааг дуусгах боломж олгожээ.

### Тэгш хамруулан сургах боловсрол

- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан багш нарын 6 сүлжээг сургуулиуд дээр, мөн аймаг, дүүргийн түвшинд байгуулав. 2023 онд байгуулагдсан эдгээр сүлжээнүүд нь 2025 он хүртэл үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, багш нарт зөвлөгөө өгөх, улирал тутам сургалт явуулах, шаардлагатай материалаар хангах, цахимаар дамжуулан туршлагаа хуваалцах боломж олгосон байна. Тусгай сургуулийн багш нар зөвлөхөөр ажилладаг бөгөөд зөвлөх баг 18 багшийг сүлжээний зөвлөхөөр ажиллуулж сургажээ.
- 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих зорилгоор төслийн 18 зорилтот сургуульд бүрэн тоноглогдсон “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулав. 2025 онд эдгээр танхимуудад 156,911,370 төгрөгийн санхүүжилтээр Тайвшруулах буланг нэмж байгуулсан юм. “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” нь хичээлийн болон хичээлийн дараа ч нээлттэй ажилладаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 446 хүүхдэд үр өгөөжөө өгч байна.
- Төслийн хүрээнд зорилтот сургуулийн 18 багшийн мэдлэг чадварыг сайжруулахын тулд “Тэгш хамруулах боловсрол”-ын багшийн нэг жилийн бакалаврын хөтөлбөрт хамруулав. Эдгээр багш мөн Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан дохионы хэлний анхан шатны сургалтад хамрагджээ.
- Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 25, 70, 55, 116 дүгээр тусгай сургуульд 15 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа туршлагатай багш нарыг сонгож, 2023-2025 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-аар дамжуулан тусгай хэрэгцээтэй сурагчтай ажиллаж буй багш нарт зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.
- Боловсролын яам болон харьяа байгууллагын 50 ажилтанд зориулсан дохионы хэлний 5 өдрийн сургалтыг 2025 оны 4-р сарын 28-наас 5-р сарын 2-нд зохион байгуулав.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үе тэнгийн найз нараар нь дамжуулан дэмжлэг үзүүлэх, сурталчилах, мэдлэг олгох нөлөөллийн ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 16-25-нд 15 зорилтот сургуульд явууллаа.

## Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ

- Хоол зүйчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 36 хүнийг хамруулж, бүрэн тэтгэлгээр сургав. 2024 онд 8, 2025 онд 28 хүн төгсөж, гэрээт сургуулиудаа ажиллаж байна.
- Улаанбаатар хотын 9 дүүрэг, 11 аймгийн 45 ерөнхий боловсролын сургуульд 45 төрлийн 22,000 ширхэг 3.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий гал тогооны тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нийлүүлж, бүрэн суурилуулав.
- Боловсролын яамнаас орон нутгийн болон алслагдсан бүсийн дотуур байрны сурагчдад зориулсан хүүхэд төвтэй хоол тэжээл, эрүүл мэндийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулсан. Бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан гурван сургалтын гарын авлага хэвлүүлж, зорилтот дотуур

## Хосолсон сургалт

- Мэдээллийн технологийн нэр томъёоны стандарт болох ISO/IEC 2382-36 (Суралцах, боловсрол, сургалт хэсэг)-ыг Монголын боловсролын салбарт хэрэглэхээр Стандарт, хэмжил зүйн газраас батлав. Мөн хосолсон сургалт явуулах багш, байгууллагад зориулсан 2 төрлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Боловсролын сайдаар батлуулсан байна.
- Төслийн зорилтот 85 сургуульд хосолсон сургалт хэрэгжүүлэх орчин бүрдүүлж, нийт 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Цахим танхим” байгуулснаар холимог сургалт явуулах боломжтой боллоо.
- Технологид суурилсан хосолсон сургалтын загварууд боловсруулж, өргөжүүлсэн. Ингэснээр хот, хөдөөгийн ялгааг багасгах, тэгш хамруулах, чанартай, хувь хүнд тохирсон сургалтын хүртээмжийг сайжруулах зорилготой.
- Хосолсон сургалтын дөрвөн модулийг 85 сургуульд туршилтаар хэрэгжүүлэв.
- Зорилтот сургуулиудын 164 багш, мэдээллийн ажилтанд (78 мэдээллийн технологийн ажилтан, 86 захиргааны ажилтан) мэдээллийн сүлжээний хэвийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн, техник хэрэгслийн

байранд туршиж үзсэн бөгөөд 30 дотуур байрны 3206 сурагчид ашиг тусаа өгчээ. Хүүхэд төвтэй хоол тэжээл, эрүүл мэндийн хөтөлбөрийн хялбаршуулсан хувилбарыг одоо улс орон даяар дотуур байртай ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж байна.

- 45 сургуулийн 150 тогооч, 42 хоол зүйч 2023, 2025 онд онол, дадлага хосолсон хоёр үе шаттай сургалтад хамрагдав. Оролцогчдод мэргэжлийн гэрчилгээ гардуулж, тогоочийн иж бүрэн хувцас, хоолны гүний хэм хэмжигч, давс хэмжигч зэрэг шаардлагатай хэрэгслүүд өгөв.
- 2025 онд 45 зорилтот сургуулийн бага ангийн сурагчид, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчдаас сургуулийн үдийн хоолны чанар, шим тэжээлийн талаарх судалгаа авч, цаашид үдийн хоолны хяналтад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх үндэс суурь тавилаа.

бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгууллаа.

- Улаанбаатар хотод багш нарт зориулсан сургагч багшийн сургалт зохион байгуулав. Энэ сургалт нь 5 модультай бөгөөд хосолсон сургалтыг заах арга зүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг уялдуулах, хосолсон сургалтын үндсэн ойлголт, мөн сургалтын үнэлгээ зэрэг сэдвүүдийг хамарчээ. Нийт 85 сургуулийн 164 багшийг сургагч багшаар бэлтгэж, тэдгээр багш нар нь өөрсдийн сургуулийн 1320 багшид мэдлэгээ түгээн дэлгэрүүлэв. Хүүхдийнхээ хосолсон сургалтыг дэмжих оролцоог бэхжүүлэх зорилгоор 4622 эцэг эхэд сургалт явуулав. Төслийн хүрээнд зорилтот 85 сургуулийн 255 багш хосолсон сургалтын 4 модулийг хэрхэн хэрэгжүүлж байгаа шилдэг туршлагаа хуваалцав. Мөн туршилтын хөтөлбөрт оролцоог өргөжүүлж, сурагчдад дэмжлэг үзүүлэх талаар зөвлөгөө өглөө. Үүнээс гадна Боловсролын яам, Боловсролын ерөнхий газрын Цахим боловсрол, статистик мэдээллийн газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 18-наас 2025 оны 3 дугаар сарын 21-ний хооронд 90 сая төгрөгийн шагналын сантай улсын хэмжээний “Цахим контентын уралдаан” зохион байгуулав.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролын ердийн сургуульд хамрагдах боломж, нөхцөл сайжирснаар 177 сурагч шинээр нэмэгдэж, зорилтот сургуулиудад нийт 1027 сурагч суралцаж байна.
- 2024-2025 оны хичээлийн жилд 18 зорилтот сургуульд суралцаж буй нийт 26103 сурагчийн 20142 нь (78.5%) хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийнхэндээ тусламж дэмжлэг үзүүлдэг эерэг хандлагыг төлөвшүүлж, сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд илүүхүртээмжтэй, эерэг болсон байна.
- Төслийн шууд үр дүнд 48,200 сурагч долоо хоногийн 5 өдөр стандарт орчинд халуун хоолоор үйлчлүүлж байгаа бөгөөд хичээлдээ идэвхтэй оролцох, хоол тэжээл сайжрах, хүүхдийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх зэрэг сайн үр дүнгүүд гарч байна.



Ерөнхий боловсролын сургуулийн 36 хоол зүйчийг 1-1.5 жилийн хугацаатай, 41-72 кредит цагийн хөрвүүлэх сургалтаар хоол зүйч, шим тэжээл судлаач мэргэжлээр сургав.



“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн хэрэгжилтийг танилцуулах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ. 2025 оны 12 дугаар сарын 5. Улаанбаатар хот



## “ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИП БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол” олгох төслийг 2025 онд амжилттай хэрэгжүүлж дуусгав. 2019-2025 онд Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн 29 суманд хэрэгжсэн уг төслийг Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сангийн 2.7 сая ам.долларын буцалтгүй тусламжаар санхүүжүүлжээ.

Энэхүү төсөл нь хөдөө орон нутгийн хүүхэд, залууст бизнес эрхлэх, хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох зорилгодоо бүрэн дүүрэн хүрсэн юм. Эдгээр ур чадварын тусламжтайгаар хүүхдүүд сурлагын амжилтаа сайжруулж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэн, олон талын мэдлэгтэй болж, ирээдүйн ажил эрхлэлт, орлогын боломжуудаа тодорхойлж чадсан байна.

## ТӨСЛИЙН АМЖИЛТ:

Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар анги, Насан туршийн суралцахуйн төв, Мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчид, сургууль завсардсан, ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй

# 14-25

насны нийт

# 8,773

хүүхэд, залуучууд Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх ESEL сургалтад хамрагдав.

Шинэлэг хэлбэрийн “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүний багцыг олон улсын хандлага, орон нутгийн онцлог, хэрэгцээ, оролцоонд тулгуурлан боловсруулж, олон талт хамтын ажиллагаагаар дамжуулан туршин хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэв.

Сургалтын хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвараа бодитоор туршин хэрэгжүүлж, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх бичил төслийн санхүүжилтийн механизм бий болгож, пич уралдаан зохион байгуулан хүүхэд, залуучуудын боловсруулсан бичил төслийг санхүүжүүлэн тэтгэлэг олгов.

Хамтрагч талуудын оролцоог ханган, ESEL хөтөлбөрийн эко систем хөгжүүлэх замаар төслийн хэрэгжилтийн үр дүн, өгөөжийг нэмэгдүүлж, амжилт, сургамжаа дүгнэн төслийн сайн туршлага, хөгжүүлсэн арга аргачлалаа хуваалцаж, төслийн тогтвортой байдлын стратеги боловсруулан түгээв.



## ТӨСЛИЙН ГОЛ ҮР:

- Экспансив сургалтын онолд тулгуурлан “Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийг багц хэрэглэгдэхүүний хамт боловсруулж, хосолсон ESEL сургалт нэвтрүүлэв.
- Төслийн зорилтот 5 аймаг, 29 суманд орон нутгийн оролцогч талууд, хувийн хэвшил, эцэг эхчүүд болон сайн дурын олон нийтийн төлөөллөөс бүрдсэн Төслийн Аймгийн Зөвлөл (ТАЗ), Төслийн Сумын Зөвлөл (ТСЗ) байгуулж, төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллалаа.
- Зорилтот сумдын Ерөнхий боловсролын сургууль (ЕБС), Насан туршийн суралцахуйн нэгж (НТЧН), Мэргэжлийн боловсролын сургуулиар (МБС) дамжуулан 7 удаагийн ESEL сургалтыг зохион байгуулж, 8,773 хүүхэд, залуучууд хамрагдав.
- ESEL сургалтын хөтөлбөрийг чиглүүлэн явуулах 594 багшийг ESEL-ийн багш/зөвлөхөөр сургаж, ESEL сургалтын хөтөлбөрийн багшийн сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй 50 Мастер багш бэлтгэлээ.
- ESEL сургалтаар эзэмшсэн үр чадвараа хөгжүүлэх зорилготой 45 Энтрепренер клубыг зорилтот сумдын сургуулиудад байгуулж, уг клубээр дамжуулан 2,940 хүүхэд, залуусын идэвхтэй оролцоог хангав.
- Сургалтад хамрагдсан хүүхэд, залуучууд баг болж, орон нутагтаа хэрэгжүүлэх бизнесийн шинэ санааны 8 удаагийн пич уралдаан зохион байгуулав. Энэхүү уралдаанд нийт 3,286 хүүхэд, залуучууд оролцож бичил төслөө танилцуулснаас 1,471 нь тэтгэлэг авав.
- Пич уралдаанд шалгарсан бичил төслийн 360 багт санаагаа бодитоор турших, үр чадваруудаа бодит амьдрал дээр ашиглахад нь дэмжлэг болох 1000 ам.доллар хүртэлх санхүүжилтийн тэтгэлэг олгосон байна.
- Төслийн зорилтот аймаг, сумын хэмжээнд 5 Бизнес көүч, 211 ментор, 224 үе тэнгийн менторуудыг чадавхжуулж, бичил төсөл хэрэгжүүлж буй хүүхэд, залууст дэмжлэг үзүүлэх дэмжлэгийн механизмыг бий болгов.
- Бичил төсөл хэрэгжүүлэгч багуудын хооронд туршлага солилцох орон нутгийн, үндэсний арга хэмжээ зохион байгуулж 1,019 хүүхэд, залуус оролцов.
- Энтрепренершиппийн боловсрол, үйл ажиллагааг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сургуулийн менежментийн хөгжлийг дэмжих зорилгоор зорилтот 5 аймгийн 6 сумын 6 ЕБС-д Сургуульд суурилсан энтрепрайз (ССЭ) санаачилгыг хэрэгжүүлэв.
- Төслийн гарааны, төгсгөлийн, үр шим хүртэгсдийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, тайлан бэлтгэн хуваалцав. Зөөлөн үр чадварыг үнэлэх үндэсний чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулж, ESEL хөтөлбөрийн ажиглалтын рубрик судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулан түгээв.
- Төслийн хэрэгжилтийн явцыг тасралтгүй үнэлэх, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зорилгоор олон талт оролцогчдын оролцоонд суурилсан хяналт, үнэлгээний цогц механизм бий болгон хэрэгжүүлэв. Төслийн амжилтын түүхүүдээ бэлтгэж, төрөл бүрийн хэлбэрээр түгээв.

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

<p><b>8,773</b></p> <p>ESEL сургалтад хамрагдсан нийт оролцогч</p>	<p><b>8,253</b></p> <p>ESEL сургалтын төгсөгчид</p>	<p><b>5,529</b></p> <p>ESEL-ийн суурь үр чадвар эзэмшсэн суралцагчид</p> 	
<p><b>1,471</b></p> <p>Бичил төсөл хэрэгжүүлэгч хүүхэд, залуучууд</p>	<p><b>360</b></p> <p>Бичил төсөл хэрэгжүүлсэн баг</p> 	<p><b>3,286</b></p> <p>Пич уралдаанд бичил төслөө танилцуулсан хүүхэд, залуучууд</p>	<p><b>1,331</b></p> <p>Бизнесээ зах зээлтэй холбосон хүүхэд, залуучууд</p>
<p><b>435</b></p> <p>Ментор, үе тэнгийн ментор</p>	<p><b>594</b></p> <p>ESEL сургалтын бэлтгэгдсэн багш</p> 	<p><b>50</b></p> <p>ESEL сургалтын Мастер багш</p>	<p><b>1,019</b></p> <p>Туршлага солилцох арга хэмжээнд оролцсон хүүхэд, залуучууд</p>
<p><b>6</b></p> <p>ССЭ хэрэгжүүлэгч сургууль</p> 	<p><b>45</b></p> <p>энтрепренер клубууд</p>	<p><b>+2,940</b></p> <p>энтрепренер клубын гишүүд</p>	




**Зүүн гар талаас: Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай  
Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх (ESEL) сургалтын гарын авлагын  
багцыг Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очирт гардуулан өглөө. 2025 оны 3 дугаар  
сарын 28. Улаанбаатар хот**



**Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч, ESEL-ийн суралцагч, МУИС-ийн оюутан  
Э.Мөнхжин:**

Би ESEL сургалтад хамрагдаж, гурван жил төслийн үйл ажиллагаанд оролцсон. Би хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирээд, ангийнхаа хүүхдүүдийг манлайлан, өөрийгөө хамт олондоо бодитой хувь нэмэр оруулж чадна гэдгээ ойлгож эхэлсэн. Энэ туршлага надад ирээдүйд дэлхийн олон улс орноор аялах итгэл, хүсэл тэмүүлэл төрүүлсэн юм. ESEL сургалтын ачаар илүү бүтээлч, алсын хараатай сэтгэж сурсан гэж боддог. Мөн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд хамгийн чухал нь юу болохыг харж сурсан байгаа. Олж авсан мэдлэг, хуримтлуулсан туршлага маань бидэнд үнэлж баршгүй үнэ цэн бүтээж, ирээдүйдээ итгэл төгс байхад үнэтэй хувь нэмэр оруулсанд чин сэтгэлээсээ талархаж явдаг. Бид бол эх орноо хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй залуучууд.



“ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР,  
ЭНТРЕПЕНЕРШИП БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ (2019-2025)

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН СЕМИНАР



LEARN TOGETHER  
CREATE TOGETHER

ХАРИЛЦАН СУРЬЯ  
ХАМТДАА БҮТЭЭЭ

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепнершип боловсрол” олгох төслийн үр дүнгийн семинарын оролцогчид. 2025 оны 6 дугаар сарын 9. Улаанбаатар хот

## ОЛОН УЛСЫН ӨСВӨРИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН УРАЛДААН 2025

Хүүхдийг Ивээх Сан, “Хөгжлийн шийдэл” ТББ, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газартай хамтран 2017 оноос Global Youth Entrepreneurship Challenge (GYEC) буюу Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдааныг Монголд зохион байгуулж байна.

Энэ жилийн үндэсний тэмцээнд оролцох долоон баг шалгарч, тэд 12 цагийн дотор “Гар утасны донтолтоос ангижрах нь: Дэлгэцийн донтолтыг бууруулах дараагийн чухал санаа” сэдвийн хүрээнд бизнес санаагаа боловсруулж, түүнийхээ дагуу бүтээгдэхүүний загвар гаргаж, бизнес төлөвлөгөөгөө танилцуулав. Шүүгчид багуудыг бүтээлч байдал, инноваци, шинэ технологийн хэрэгжүүлэлт, санхүүгийн тооцооллын нарийвчлал, үйлдвэрлэлийн төлөвлөлт, маркетингийн судалгаа, төлөвлөлт, харилцаа холбоо зэрэг таван үндсэн шалгуураар үнэлсэн юм.

“Jimmy Neutron” баг 2025 оны Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдаанд эрүүл мэндийн шинэлэг дижитал аппликейшнаараа тэргүүн байр эзлэв. “LABO” баг дууг тархинд шууд дамжуулдаг чихэвчтэй ухаалаг цагны шийдлээрээ хоёрдугаар байр эзэлсэн бол “Team Achievers” баг хэрэглэгчдийг оноо, тэмдэгээр шагнаж, дэлгэцийн цагийг багасгахыг уриалдаг хөдөлгөөнт аппликейшнаар гуравдугаар байр эзэлсэн байна.

Үндэсний тэмцээний ялагчид 2025 оны 5 дугаар сарын 17-нд Япон Улсын “Center for Entrepreneurship Development” байгууллагаас цахимаар зохион байгуулсан өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг, туршлагаа хуваалцах зорилготой “Олон Улсын Өсвөрийн Энтрепренерүүдийн Тэмцээн”-д амжилттай оролцжээ. Олон улсын уралдаан нь дэлхийн хэмжээний компанид сонголын бэрхшээлтэй ажилчдыг ажлын байранд хамруулах, тэдний өсөлт хөгжлийг дэмжихэд туслах шинэлэг, зардал багатай технологийн шийдэл хайх сэдэвтэй байв.



“Олон Улсын Өсвөрийн Энтрепренерүүдийн Уралдаан 2025”-ийн үндэсний тэмцээний оролцогчид шүүгчдийн хамт. 2025 оны 4 дүгээр сарын 5. Улаанбаатар хот



БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагууд тус байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн хэрэгжилтийн явцтай танилцахаар Монголд зочлов. Улаанбаатар хотын Налайх дүүрэг дэх төслийн талбайд. 2025 оны 10 дугаар сарын 20

## “ОЙН ТӨГӨЛ БҮТЭЭГЧ ХҮҮХДҮҮД” ТӨСӨЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээнээс гаргасан судалгаагаар, Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа орнуудын нэг болжээ. Газарзүйн байрлалын хувьд дэлхийн дулаарлын нөлөөнд нэн тэргүүнд өртөх магадлалтай байгаа юм. Бүс нутагтаа агаарын чийгшил харьцангуй багатай, далайн чийглэг уур амьсгалаас уулсаар халхлагдсан тул үүлгүй өдрийн тоог нэмэгдүүлж, хүр борооны хэмжээг багасган, халуун хуурай болох нөхцөлийг жилийн турш бүрдүүлж байна.

Хүүхдийг Ивээх Сан нь 2024 оноос БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төсөл хэрэгжүүлж байна. Гурван жилийн хугацаатай энэхүү төсөл нь мод тарих, арчилах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад бодит дэмжлэг үзүүлэх, зорилтот газартаа хүүхэд, залуучуудыг байгаль орчноо хамгаалах ажилд татан оролцуулах зорилготой юм.



## 2025 ОНЫ ГОЛ ҮР ДҮН:

### Талбайн бэлтгэл ажил - Дэд бүтэц

Дүүргийн Засаг дарга Налайхад 5 га газрыг төсөлд ашиглахыг түр хугацаагаар зөвшөөрсний дагуу (албан ёсны зөвшөөрөл хүлээгдэж байна) талбайг хамгаалж, хашаа барив. Мөн авто машин болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүд худалдан авлаа. Трактор болон бусад холбогдох жижиг оврын тоног төхөөрөмж, жижиг ачааны машин (портер) ашиглаж, төслийн газрын тавны нэгийг амжилттай боловсруулж, хаврын тариалалтад бэлтгэсэн. Есдүгээр сард 80 метрийн гүнтэй усны худаг өрөмдөв. Үүний зэрэгцээ 10 киловатт-цагийн багтаамжтай батарейтай 5кВт нарны эрчим хүчний үүсгүүр суурилуулж, ойролцоогоор 600 метр кабель шугам татлаа. Түүнчлэн, талбайд хяналтын систем суурилуулав.

### Мод үржүүлгийн газар

Төслийн талбайд модны суулгац тариалах зориулалттай тус бүр 6-20 метр хэмжээтэй, усалгааны системээр тоноглогдсон хоёр хүлэмж барив. Тус хүлэмжид ирэх жилүүдэд модны суулгацыг ургуулж, арчлах, ургалт нь зогссон модыг дахин тарих, орон нутгийн иргэдэд орлого олоход дэмжлэг үзүүлэх юм. Мөн төслийн талбай дахь үйл ажиллагаанд зориулан агуулах, ажилчдын байр барьж, био жорлон суурилуулав.

### Мод тариалалт

2025 онд төслийн талбайд 23 төрөл зүйлийн 4,000 гаруй мод тарив. Тариалалтыг улирлын чанартай явуулсан бөгөөд 41% нь хавар, 1% нь зун, 58% нь намрын улиралд тариалжээ. Эдгээр үйл ажиллагаанд 1,000 гаруй хүн оролцсон бөгөөд тэдний 39% нь эрэгтэй, 61% нь эмэгтэй, 82% нь хүүхдүүд байлаа. Мөн хүлэмжинд 7 төрөл зүйлийн 600 орчим суулгац, мөчир бэлтгэв.

### Мод тарих сургалт

Төслийн хүрээнд дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран орон нутгийн 200 иргэнийг зохион байгуулалтад ороход нь дэмжлэг үзүүлж мөн мод тарих үйл ажиллагаанд оролцуулав. Эхний ээлжид 5 бүлэг байгуулсан бөгөөд нийт 25 бүлэг байгуулах зорилготой байлаа. Оролцогчдод мод тарих, хамтын зохион байгуулалт, тогтвортой амьжиргааны арга барилыг ашиглан ногоон байгууламжийн загвар бий болгох, урт хугацаанд байгалиа хамгаалах ажлыг дэмжих сургалт явууллаа. Сургалтын дараа олон нийтийн бүлгүүд мод хүлээн авч, өөрсдийн хамаарал бүхий нийтийн талбайдаа 300 гаруй мод тарьсан байна.

Нийт 1,500 гаруй хүн танхимын, 1,000 гаруй хүн мод тарих талбайн сургалтад хамрагджээ.

### Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгох сургагч багшийн сургалт

Хүүхдийг Ивээх Сан нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-тэй хамтран сургагч багш нарт зориулсан эрчимжүүлсэн сургалт зохион байгуулав. Тус төвийн чадварлаг багш нар оролцогчдод дадлага сургалтын зэрэгцээ онолын мэдлэг олгосон байна. Үүний үр дүнд их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн багш, оюутан, орон нутгийн төрийн байгууллагын ажилтан зэрэг 50 оролцогч уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг сургалтын арга зүйн цогц мэдлэгтэй болжээ. Эдгээр сургагч багш нар сургалтын дараа бие даан мэдлэг чадвар олгох 22 удаагийн сургалт семинар зохион байгуулж, 2025 оны хавар нийт 1,686 хүүхэд, залуус, иргэдийг хамруулсан байна.

### Хүүхэд, залуучуудын Эко клубийн үйл ажиллагааг дэмжив

Төсөл нь уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчноо хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зорилтот сургуулиудын сурагчдын эко клубүүдийн үйл ажиллагааг дэмждэг. 2025 онд уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг ойлгох, мод тарих ажлыг сурталчилсан бүтээлч санаачилгыг хэрэгжүүлэхэд эко клубт санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэв.

Үйл ажиллагаанд дараах зүйлс орно:

- Уур амьсгалын өөрчлөлт, мод тарих, биологийн олон янз байдлын талаарх мэдлэг олгох нөлөөллийн

ажил, уралдаан тэмцээнийг дэмжих






- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр видео, зурагт хуудас, мэдээллийн хуудас зэрэг боловсрол олгох зүйлүүд бэлтгэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээ, дасан зохицох талаарх мэдлэгээ хуваалцах үе тэнгийнхний сургалтууд

Эко клубийн төслүүдэд 1,000 гаруй сурагч хамрагдаж, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, орон нутаг дахь ойжуулалтын ажилд залуучуудын оролцоог нэмэгдүүлсэн. Эдгээр санаачилгууд нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй, оюун санааны хувьд ухамсартай шинэ үеийг төлөвшүүлэх төслийн зорилгод хувь нэмэр оруулсан юм. Зорилтот дунд сургуулиудын 6 эко клуб төслийн дэмжлэгээр байгаль орчны чиглэл бүхий жижиг төслүүд санаачилж хэрэгжүүлсэн. Үр дүнг 2026 оны эхний болон хоёрдугаар улиралд мэдээлэх болно.

### Олон нийтэд зориулсан нөлөөллийн ажил

2025 оны 5 дугаар сарын 3-нд Налайх дүүрэгт уур амьсгалын боловсрол олгох зорилгоор нээлттэй микрофон өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн иргэд идэвхтэй оролцов. Нөлөөллийн ажлын үеэр мэдээллийн ширээн дээр интерактив, тоглоомд суурилсан сургалтын аргыг ашигласан бөгөөд 100 гаруй хүн оролцлоо. Мөн орон нутгийн 23 уран бүтээлч тоглолтоо сонирхуулж, урлагийг байгаль орчны мэдээлэлтэй хослуулав.

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

<p><b>4,000</b></p> <p>гаруй 23 төрөл зүйлийн 4,000 гаруй мод тарьсан бөгөөд хүлэмжинд 7 төрөл зүйлийн 600 суулгац, мөчир бэлтгэв.</p>	<p><b>1,000</b></p> <p>Мод тарихад оролцсон хүн:</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;"> <div style="text-align: center;">  <p><b>39%</b></p> <p>эрэгтэй</p> </div> <div style="text-align: center;">  <p><b>61%</b></p> <p>эмэгтэй</p> </div> <div style="text-align: center;">  <p><b>82%</b></p> <p>хүүхдүүд</p> </div> </div>	
<p><b>50</b> ▶ <b>30</b> <b>2,000</b></p> <p>Сургагч багш бэлтгэв</p> <p>Сургалт зохион байгуулсан</p> <p>Хүн мод тарих болон уур амьсгалын сэдэвт сургалтад хамрагдав</p>	<p></p> <p>Уур амьсгалын өөрчлөлтийн сургалтын гарын авлагыг боловсруулж, түгээсэн</p> <p>Олон нийтийн бүлгийн оролцоо:</p> <p><b>200</b></p> <p>гишүүнийг сургасан</p>	
<p>Уур амьсгалын боловсролын сургалт явуулсан:</p> <p><b>5</b> сургууль (багш, ажилтнууд болон сурагчид)</p>	<p>Эко клуб байгуулсан:</p> <p><b>5</b> сургууль</p> <p></p>	<p>Оролцсон сурагчид:</p> <p><b>1,000+</b></p> <p>Сурагчдын хэрэгжүүлсэн төслүүд:</p> <p><b>5</b> эко клуб</p>
<p>Налайх дүүрэгт 300 гаруй хүүхэд, залуучууд болон оршин суугчдыг хамруулсан нээлттэй микрофон өдөрлөг болж, байгаль орчинд ээлтэй зан үйл, уур амьсгалын талаарх мэдлэг дээшлүүлэв.</p>	<p>Сошиал мэдээнүүд болон 11 хэвлэлийн мэдээ, 12 рийл, 5 амжилтын түүх, нэг телевизийн мэдээ нийтлэгдэж, нэг мэдээлэл дунджаар 2,934 үзэлттэй байв.</p>	



Улаанбаатар хотын Налайх дүүргийн ерөнхий боловсролын “Голомт” сургуулийн сурагч Ц.Баясгалан:

Би багаасаа л дүүрэн модтой гоё орчинд амьдрахыг хүсдэг байсан. Мод бидэнд амьсгалах цэвэр агаар бэлэглэдэг учраас илүү олон мод тарихыг хүсэж байна. Би сургалтад суух үеэрээ олон мод тарихаасаа илүү арчилж, ургуулах нь чухал гэдгийг ойлгосон. Тиймээс би цаашидаа ч гэсэн тарьсан модоо арчлах ажилд оролцох болно.



## “ДЕНАН” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан АНУ-д төвтэй “Денан төсөл”-ийн санхүүжилтээр Архангай аймгийн Тариат суманд 2012-2022 онд эрүүл мэндийн төсөл амжилттай хэрэгжүүлсэн юм. Энэхүү амжилтдаа тулгуурлан төслөө өргөжүүлж, 2017 оноос Архангай аймгийн Эрдэнэмандал суманд, 2022 оноос Говь-Алтай аймгийн Чандмань суманд, 2025 оноос Завхан аймгийн Түдэвтэй суманд тус тус хэрэгжүүлж байна.

Уг төслөөр сумын эрүүл мэндийн төвийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай санхүүгийн болон тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж ирлээ. Үүнд, оношилгооны аппарат хэрэгсэл, эм тариа, лабораторийн урвалж бодис зэрэг зүйлс багтаж байгаа юм. Үүнээс гадна, зорилтот сумдын иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийж, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор хүүхэд залуучууд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай зохион байгуулж байна.

“Денан төсөл” нь орон нутгийн эрүүл мэндийн төвүүдэд тогтвортой хөрөнгө оруулалт хийснээр алслагдсан сумдын иргэдийн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

# ТӨСЛИЙН ҮР

## Шүдний өвчний урьдчилан сэргийлэх үзлэг

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Шүдний кабинетийн хувьд энэ жилийн онцлох гол ажил нь зэргэлдээх 30 км-ийн зайтай орших Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрүүл шүдхэн” төсөл хэрэгжүүлж, иргэдийг шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан явдал байв. Энэхүү арга хэмжээгээр цэцэрлэг, сургуулийн 363 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийн, 204 хүүхдийн шүд эмчилж, 81 хүүхдийн шүдэнд кооролтын эсрэг түрхлэг хийжээ. Шүдний эрүүл мэндийн суурь үзүүлэлт 5.2 хувиас 21.7 хувь болж, 4 дахин сайжирсан байна. Түүнчлэн, бага, дунд сургуулийн сурагчдад шүдний эрүүл мэндийн талаарх найман сургалт явуулсан бөгөөд сурагчдын амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг 10%-иар нэмэгдэв. Эдгээр үйл ажиллагаа нь шүдний өвчнийг эрт илрүүлэх, хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх мэдлэгийг сайжруулахад хувь нэмэр оруулжээ.

## Сургуулийн ундны ус, ариун цэврийн дэд бүтцийг сайжруулав

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын албан хүсэлтээр 2025 онд ерөнхий боловсролын сургууль болон дотуур байранд зориулсан худаг гаргаж, ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлээ. Үүний үр дүнд Чандмань сумын сургуулийн 485 сурагч ундны устай болж, ариун цэврийн өрөөг сургууль дотроо хэрэглэх болжээ. Энэ арга хэмжээ сургуулийн орчныг цэвэр, эрүүл болгож, хүүхдүүдийг эрүүл байлгаж, хичээлдээ тогтмол ирэх нөхцөл бүрдүүлсэн байна.

## Сурагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж байна

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн клуб 9-12-р ангийн 25 сурагчтай бөгөөд тус клубт “Амилуулах суурь тусламж”-ийн болон бусад тоног төхөөрөмж өглөө. Эдгээр тоног төхөөрөмжийг клубынхаа үйл ажиллагаанд тогтмол хэрэглэж, сурагчдад “Амилуулах суурь тусламж” болон анхны тусламжийн чиглэлээр сургалт, дадлага хийх, туршлагажих боломж олгодог. Энэхүү амжилтад тулгуурлан “Денан” төслийн хүрээнд Завхан аймгийн Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуульд эрүүл мэндийн клуб байгуулсан юм. Тус сургуульд 1-12-р ангийн 302 сурагч суралцдаг. Шинээр байгуулагдсан эрүүл мэндийн клубын сурагчдын санаачилгаар хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, олон нийтийн эрүүл мэндийн

мэдлэгийг сайжруулах зэрэг мэдээлэл, сурталчилгааны ажлууд явуулж байна.

## Түдэвтэй сумын иргэдийн шүдний тусламж үйлчилгээг сайжрууллаа

2025 оны 4 дүгээр сард Завхан аймгийн Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвд иж бүрэн тоног төхөөрөмж бүхий шүдний кабинет байгуулж, хүлээлгэн өглөө. Шүдний кабинет байгуулснаас хойш нийт 611 хүн тусламж, үйлчилгээ авчээ. Үүнээс гадна шинэ тоног төхөөрөмжөө ашиглан урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн бөгөөд хүүхдүүдийн шүдний эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2025 оны 3 дугаар сартай харьцуулахад 8.7%-иар сайжирчээ. Энэхүү хөрөнгө оруулалт нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжинд шууд нөлөөлж байна.

## Тариат сумын Эрүүл мэндийн төвд биохимийн анализатор хүлээлгэн өгөв

Архангай аймгийн Тариат сумын Эрүүл мэндийн төвийн оношилгооны чадавхийг бэхжүүлэх, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор 2025 онд хагас автомат биохимийн анализатор хүлээлгэн өгөв. Энэхүү анализатор нь цагт 200 хүртэлх биохимийн шинжилгээ болох элэг, бөөр, нойр булчирхайн үйл ажиллагааны шинжилгээ, цусан дахь глюкозын хэмжээ, электролитийн тэнцвэрийг хэмждэг. Сумын Эрүүл мэндийн төвийн биохимийн шинжилгээ хийдэг тоног төхөөрөмжийг шинэчлэснээр орон нутгийн иргэд цаг алдалгүй, оношилгоо, шинжилгээ хийлгэх боломж бүрдэж байна.

## Нийгмийн эрүүл мэндийн талаарх ойлголт, чадавхийг бэхжүүлэх сургалт боллоо

Хүүхдийг Ивээх Сангаас нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор 2025 оны 4 дүгээр сард Архангай аймагт зохион байгуулсан таван өдрийн “Нийгмийн эрүүл мэндийн мастер” сургалтыг зохион байгуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлэв. Тус сургалтыг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 30 оролцогчийн 23 нь багийн бага эмч нар байлаа. Оролцогчид байгаль орчин, өсвөр үе, сэтгэцийн эрүүл мэнд ба эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны талаарх мэдээлэл авсан нь нийгмийн эрүүл мэндийн суурь зарчмууд болох эрт, илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чадавхийг орон нутгийн түвшинд бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан сургалт боллоо.



Зүүн гар талаас: “Денан төсөл”-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Шин Жийн Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Бат-Эрдэнэд зөврийн мобайл технологийн аппарат, тоног төхөөрөмжийн иж бүрдэл гардуулан өгөв. 2025 оны 9 дүгээр сарын 2. Говь-Алтай аймаг. Чандмань сум

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

- Завхан аймгийн Түдэвтэй суманд “Денан” төслийн хүрээнд шүдний кабинет байгуулснаас хойш **611** хүн шүдний эмчилгээ хийлгэсэн бөгөөд үүний **250** нь насанд хүрэгч, **361** нь хүүхэд байв. Үүнээс гадна иргэдэд зориулсан хоёр удаагийн шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийжээ. 2025 оны **11** дүгээр сард нийт **229** хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын шүдний кабинетаар **1329** хүн үйлчлүүлсэн бөгөөд Чандмань сумын **897**, Эрдэнэ сумын **413**, Цогт сумын **1**, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын **13** иргэн байв. Нийт **416** хүүхэд шүдний үзлэгт хамрагдаж, **913** насанд хүрэгч шүдний эмчилгээ хийлгэсэн байна.
- Чандмань сумын Эрүүл мэндийн төвд **4606** өвчтөн үзлэг хийлгэсэн бөгөөд үний **1126** нь урьдчилан сэргийлэх үзлэг (**334** хүүхэд, **892** насанд хүрэгчид), **211** дуудлагын түргэн тусламжийн үйлчилгээ, **240** яаралтай тусламжийн үйлчилгээ (**59** хүүхэд, **181** насанд хүрэгчид) багтжээ.



**Завхан аймгийн Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төвийн шүдний эмч Д.Гандиймаа:**

Шүдний кабинетаар шүдний ёзоор, цоорол, сүвгийн эмчилгээ, түрхлэг зэрэг шүдний эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлж байна. Мөн сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө өгдөг. Иргэдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, зөв угаах дадал хэвшүүлэх талаар мэдээлэл сурталчилгааны ажил явуулж байна.

# ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хүүхдийг Ивээх Сан дэлхийд 1919 оноос, Монголд 1994 оноос үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд шашин, улс төрөөс ангид байж, хүүхдийн төлөөх ажил үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг болсон юм. Өнөөдөр Хүүхдийг Ивээх Сан дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан бусад улсууд дахь Хүүхдийг Ивээх Сантай нягт хамтран ажиллаж, тэднээс дэмжлэг, тусалцаа авахын зэрэгцээ өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлж байгаа юм.

2025 оны хувьд Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа олон чиглэлээр өргөжүүлсэн жил байлаа.

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн урилгаар Япон, Австрали, БНСУ, Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн захирал, менежер, ажилтнууд Монголд зочиллоо. Тэд санхүүжүүлж буй төслүүдийнхээ хэрэгжилт, үр дүнтэй танилцсанаас гадна хоёр байгууллагын цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцжээ.

Япон улсын “Фүкүй” их сургуулийн эрдэмтэн, судлаачдын баг Хүүхдийг Ивээх Сан болон “Жайка” олон улсын байгууллагын урилгаар Монголд зочилж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав. Мөн нийслэл болон орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал зэрэг салбарын төлөөллүүдэд сургалт

явуулсан юм. Тус багийнхан энэхүү аяллаар хүүхдийн сурах, амьдрах орчинг тойрсон бэрхшээлүүдийн талаар мэдээлэл цуглуулах, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, Жайка байгууллагын хөтөлбөрт оролцогчид, хамтрагчдад хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчилах зорилготой байв.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах” төслийн санхүүжүүлэгч Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн төлөөллүүд 2025 оны 4 дүгээр сарын 20-27-нд Монголд айлчилж, Улаанбаатар хот, хөдөө орон нутаг дахь төслийн оролцогч талууд болон үр шим хүртэгчидтэй уулзаж, зорилтот сургуулиуд, хамтарсан багуудад гарч буй үр нөлөөтэй танилцав. Түүнчлэн Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагын баг, төслийн ажилтнуудтай уулзаж, үр дүн, тулгарч буй асуудлууд, сургамж, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан юм.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фиона Блайт, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Игавахара Масарү нар Хүүхдийг Ивээх Сангийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж буй сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлгээр зочлов.

Бутаны Хүүхдийг Ивээх Сангийн төлөөлөл Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийнхантай уулзаж, төсөл, хөтөлбөрүүдтэй танилцав.

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн урилгаар Сөүл хотод

зочилж, хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар ярилцаж, харилцан туршлага солилцов.

Боловсролын яамны төлөөлөл, Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага Австралийн Мельбурн хотод зочилж, Монгол Улсын боловсролын салбарт цаашид хамтран ажиллаж, шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх талаар Австралийн Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагуудтай ярилцсан юм. Түүнчлэн Монгол Улсын боловсролын

салбарт цаашид хамтран ажиллаж, шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх талаар саналаа солилцов. Энэхүү айлчлал Боловсролын дэлхийн түншлэлд хамтарсан төсөл өргөн мэдүүлэх, боловсролын салбарт хувийн хэвшлийн оролцоо, инноваци, дижитал сургалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлчилгээг сайжруулах шинэ санаачилгуудыг хэрэгжүүлэх, хоёр талын байгууллагуудын урт хугацааны стратегийн түншлэлийг бататгах зорилготой байлаа.



**БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн захирал, удирдлагууд 2025 оны 10 дугаар сарын 19-23-нд Монголд зочилж, “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн явцтай танилцав. Тус баг БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн Гүйцэтгэх захирал Габриэл Жон Тэ Ёон, Маркетинг хариуцсан захирал Им Жун Ил, Хөрөнгө оруулалт, санхүүжилт хариуцсан захирал И Сү Кён, Сайн үйлсийн санхүүжилт хариуцсан захирал Чой Жи Вон болон Олон улсын стратегийн захирал И Чэ Гуан нараас бүрдсэн юм.**



Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн төлөөллүүд 2025 оны 4 дүгээр сарын 20-27-нд Монголд айлчилж, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах” төслийн хэрэгжилттэй танилцав. Багийн бүрэлдэхүүнд Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын хөтөлбөрийн захирал Helen I’Anson, ахлах ажилтан Lilian Tong, дотоод хөтөлбөрийн менежер Kevin Lau, дижитал маркетингийн ажилтан Alison Hui нар багтсан байна. 2025 оны 4 дүгээр сарын 21. Улаанбаатар хот



Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн урилгаар Сөүл хотод очиж, 2025 оны 5 дугаар сарын 5-9-нд тус байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа. Энэхүү аяллаар хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлагаа солилцох, БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн явцын талаарх мэдээлэл өгөх, цаашид хэрэгжүүлэх шинэ төслүүдийн санхүүжилтийн боломжуудыг судлах зорилготой байв. 2025 оны 5 дугаар сарын 8. БНСУ. Сөүл хот



Бутан дахь Хүүхдийг Ивээх Сангийн төлөөллүүд Монгол дахь Хүүхдийг Ивээх Санд зочилж, ажилтнуудтай уулзаж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдтэй танилцав.




Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант улсаас Монгол Улсад суух Элчин сайд Фиона Блайт Хүүхдийг Ивээх Сангийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж буй сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүдээр зочиллоо. 2025 оны 5 дугаар сарын 22. Улаанбаатар хот



Боловсролын яам болон Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн төлөөлөгчид Австралийн Мельбурн хотод Австралийн Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагуудтай уулзаж, Монголын боловсролын салбар дахь хамтын ажиллагаагаа сайжруулах, шинэ төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх талаар ярилцлаа. 2025 оны 11 дүгээр сарын 18. Австрали улс. Мельбурн хот



## САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Хүүхдийг Ивээх Сан, Жайка олон улсын байгууллагын урилгаар Япон улсын Фүкүй их сургуулийн эрдэмтэн, судлаачдын баг Монгол Улсад айлчилж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав. 2025 оны 9 дүгээр сарын 16. Улаанбаатар хот

**269,324** Хүүхдийг Ивээх Сан (Япон)

**682,378** Япон Улсын Гадаад Хэргийн Яам

**321,858** Хүүхдийг Ивээх Сан (Хонконг)

**262,023** Японы Нийгмийн Хөгжлийн Сан/Дэлхийн Банк

**258,657** GPE (Боловсролын төлөө дэлхийн түншлэл) сан

**218,779** Хүүхдийг Ивээх Сан (Солонгос)

**40,708** Денан Төсөл (АНУ)

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Ам доллараар)	2025-12-31	2024-12-31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,112,385	903,154
Авлага	19,734	297,386
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	1,335	1,730
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>1,133,454</b>	<b>1,202,271</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	178,040	202,465
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>178,040</b>	<b>202,465</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,311,494</b>	<b>1,404,735</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>		
<b>Өр төлбөр</b>		
Дансны болон бусад өглөг	36,096	6,573
Татвар, шимтгэлийн өглөг	157	222
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>36,253</b>	<b>6,795</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Нөөц ба өр төлбөр	262,637	272,658
Хойшлуулсан орлого	178,040	202,465
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>440,677</b>	<b>475,123</b>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>476,930</b>	<b>481,918</b>

<b>Цэвэр хөрөнгө</b>		
Хязгаарлалттай нөөц	232,331	384,490
Бусад цэвэр хөрөнгө	154,357	121,019
Хуримтлагдсан үр дүн	447,876	417,309
<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>834,564</b>	<b>922,817</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,311,494</b>	<b>1,404,735</b>

# ОРЛОГО БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

(Ам доллараар)	2025	2024
<b>Үйл ажиллагааны орлого:</b>		
Төсөл, хөтөлбөрийн орлого	2,048,802	2,326,272
Хандив, тусламжийн орлого	913	2,108
Бусад орлого	31,477	30,429
<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>2,081,192</b>	<b>2,358,809</b>
<b>Үйл ажиллагааны зардал:</b>		
Төсөл, хөтөлбөрийн зардал	1,784,403	2,031,053
Ерөнхий удирдлагын зардал	272,849	301,636
<b>Үйл ажиллагааны зардлын нийт дүн</b>	<b>2,057,252</b>	<b>2,332,689</b>
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>23,940</b>	<b>26,120</b>
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	2,662	3,716
Валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	3,965	(289)
<b>Тайлант жилийн цэвэр үр дүн</b>	<b>30,567</b>	<b>29,547</b>

# 2025 ОНД ХЭВЛЭГДСЭН НОМ, БҮТЭЭЛ



“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн суурь судалгааны тайлан



“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн мэдээллийн хуудас#2



“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн мэдээллийн хуудас#1



Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарт зориулсан сургалтын гарын авлага



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага



Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх арга зүй



“Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” тоглоом, сургалтын хэрэгслэгдэхүүнийг ашиглах заавар, аргачлал



Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь: Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль



Эцэг эх-багштай харилцах дэвтэр



Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр



Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын багшийн гарын авлага



“Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын суралцагчийн гарын авлага



Багшийн ажлын дэвтэр



“Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн танилцуулга



Хүүхэд хамгаалал ба багшийн ёс зүй сургалтын модуль




Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар



Энтрепренер эхлэл/ Харилцан суралцаж, хамтдаа бүтээсэн түүхүүд



Хамтдаа бүтээсэн хамгааллын түүхүүд



Өсвөр үеийнхний дуу хоолой-3



Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь



“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн үр дүн



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 1




Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 2



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 3



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 4



Хүүхэд хамгааллын үйлчилгээ болон төсвийн мэдээллийн ил тод байгах, олон нийтийн оролцоог дэмжих зорилготой “Мэдэж, оролцож, хамтдаа хяная” нөлөөллийн аяны цуврал видеонууд



Хүүхэд хамгааллын үйлчилгээ болон төсвийн мэдээллийн ил тод байгах, олон нийтийн оролцоог дэмжих зорилготой “Мэдэж, оролцож, хамтдаа хяная” нөлөөллийн аяны цуврал постерууд



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлгийн ач холбогдол, бага насны хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Эрт илрүүлж, Эрт ойлгоё” нөлөөллийн аяны цуврал постерууд



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлгийн ач холбогдол, бага насны хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Эрт илрүүлж, Эрт ойлгоё” нөлөөллийн аяны цуврал видеонууд



# ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

## САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

- Японы Хүүхдийг Ивээх Сан
- Япон улсын Гадаад хэргийн яам
- Хонконгийн Хүүхдийг Ивээх Сан
- Дэлхийн Банк (Японы Нийгмийн Хөгжлийн Сан)
- БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сан
- Боловсролын дэлхийн түншлэл

## ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

### Яам, агентлаг, харьяа байгууллага

- Боловсролын яам
- Эрүүл мэндийн яам
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Боловсролын ерөнхий газар
- Боловсролын хүрээлэн
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар
- Нийслэлийн Боловсролын газар
- Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
- Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв

### Их, дээд сургууль

- Монгол Улсын Их Сургууль
- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль

- Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль

- Налайх дүүрэг дэх Политехник коллеж

### Олон улсын байгууллагууд

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС)
- Австралийн Хүүхдийг Ивээх Сан
- Азийн Хөгжлийн Банк
- Япон улсын Элчин сайдын яам
- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)
- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)
- Нээлттэй Нийгэм Форум
- Австралийн Сайн дурын байгууллага
- Монгол-Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” төсөл

### Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, түүний агентлаг, харьяа байгууллагууд

- Баянзүрх дүүргийн 2, 19, 21, 23, 26 дугаар хороо
- Баянзүрх дүүргийн 8, 16, 18, 20, 28 дугаар хороо

- Соргинорхайрхан дүүргийн 7, 21, 22, 27, 33 дугаар хороо

- Сүхбаатар дүүргийн 9, 11, 16, 18, 19 дүгээр хороо

- Чингэлтэй дүүргийн 7, 11, 12, 17, 19 дүгээр хороо

- Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Налайх дүүрэг

- Налайх дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс

- Налайх дүүргийн Боловсролын хэлтэс

- Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээний хэлтэс

- Налайх дүүргийн Шуурхай удирдлагын төв

### Аймгуудын Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага

- Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар

- Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар

- Говь-Алтай аймгийн Боловсролын газар

- Говь-Алтай аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар
- Ховд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар
- Сэлэнгэ аймгийн Боловсролын газар
- Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар
- Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
- Баянхонгор аймгийн Боловсролын газар
- Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар

**Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв**

- Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 79, 127 дугаар сургууль
- Баянзүрх дүүргийн 79, 85, 148 дугаар сургууль
- Говьсүмбэр аймгийн Чойр, Шивээ-Овоо сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв
- Завхан аймгийн Баянтэс, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв
- Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин (II), Хархорин (III), Сант, Уянга (I), Уянга (II) Хужирт сумын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумдын ерөнхий боловсролын

- сургууль, Насан туршийн суралцахуйн төв
- Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 65, 67, 105 дугаар сургууль
- Ховд аймгийн 3, 7 болон Буянт, Булган, Алтай, Зэрэг, Манхан, Мөст, Үенч сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв
- Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 37, 49 дүгээр сургууль Политехник коллеж/ Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
- Ховд, Өвөрхангай, Завхан, Говьсүмбэр аймгийн Политехник коллеж
- Сүхбаатар аймаг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
- Налайх дүүргийн Насан туршийн суралцахуйн төв
- Налайх дүүргийн ерөнхий боловсролын 103, 109, 119 дүгээр сургууль, Голомт цогцолбор сургууль, Эрдмийн оргил сургууль
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль
- Говь-Алтай аймгийн Дарив сумын Ерөнхий боловсролын сургууль
- Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль
- Ховд аймгийн Дарви сумын Ерөнхий боловсролын сургууль
- Нийслэлийн Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын 51, 73 дугаар дунд сургууль
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 17, 50 дугаар дунд сургууль
- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 33,48 дугаар дунд сургууль

- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 2, 58 дугаар дунд сургууль
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 75, 130 дугаар дунд сургууль
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын Ерөнхий боловсролын сургууль
- Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын 7-р сургууль
- Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль
- Баянгол дүүргийн 13, 19, 40 дүгээр сургууль
- Сонгинохайрхан дүүргийн 9, 107, 121 дүгээр сургууль
- Сүхбаатар дүүргийн 3, 16, 31 дүгээр сургууль
- Чингэлтэй дүүргийн 24, 57, 117 дугаар сургууль

**Хамтарсан баг**

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 1, 3 дугаар хороо
- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7, 15 дугаар хороо
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2, 15 дугаар хороо
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6, 13 дугаар хороо
- Нийслэлийн Баянгол дүүргийн 2, 3 дугаар хороо
- Говь-Алтай аймгийн Дарив сумын Хамтарсан баг
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Баянхайрхан багийн Хамтарсан баг
- Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн Хамтарсан баг
- Ховд аймгийн Дарви сумын Хамтарсан баг

**Цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв**

- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэг
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Эмнэх баг” ӨЭМТ
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Номт Хан” ӨЭМТ
- ХБХЭБНХ-ны Сэлэнгэ аймаг дахь салбар комисс
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 16 дугаар цэцэрлэг
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэг
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын “Энх Бүрд” ӨЭМТ
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын “Оточ Мандал” ӨЭМТ
- ХБХЭБНХ-ны Баянхонгор аймаг дахь салбар комисс
- Чингэлтэй дүүргийн сумын 18 дугаар цэцэрлэг
- Чингэлтэй дүүргийн сумын 83 дугаар цэцэрлэг
- Чингэлтэй дүүргийн “Энэрэнгүй үйлс” ӨЭМТ
- Чингэлтэй дүүргийн “Мэнд-Арвижих” ӨЭМТ
- ХБХЭБНХ-ны Чингэлтэй дүүргийн салбар комисс
- Сонгинохайрхан дүүргийн 117 дугаар цэцэрлэг
- Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэг
- Сонгинохайрхан дүүргийн “Ээлтэй” ӨЭМТ

- Сонгинохайрхан дүүргийн “Анан” ӨЭМТ
- ХБХЭБНХ-ны Сонгинохайрхан дүүргийн салбар комисс
- Баянзүрх дүүргийн 32 дугаар цэцэрлэг
- Баянзүрх дүүргийн 320 дугаар цэцэрлэг
- Баянзүрх дүүргийн “Ачлахуй” ӨЭМТ
- Баянзүрх дүүргийн “Нэмүүлэн” ӨЭМТ
- ХБХЭБНХ-ны Баянзүрх дүүргийн салбар комисс

**Төрийн бус байгууллага**

- Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэн ТББ
- Гүнбилэг Оюу ТББ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ
- Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ ТББ
- Сонсголгүйн боловсрол ТББ
- Монголын Аутизмын холбоо ТББ
- Монголын Дауны холбоо ТББ
- Монголын Перинаталогийн холбоо ТББ

**Хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагууд**

- МҮОНРТ
- Ийгл Бродкастинг ХХК
- Оргил медиа менежмент ХХК
- Орлоо-Инфо ХХК
- Мэгүүн медиа ХХК
- Maven Co Creation ХХК



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Аризона төв, 4 давхарт

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save the Children in Mongolia

🐦 [x.com/scmongolia](https://x.com/scmongolia)

📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)